

# УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: УВА-2026/168/НА-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаангом хот 2026 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Т.Амармэнд Утас: 70453799, Цахим хаяг: amarmendt@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

### **1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

### **2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

- 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан
- 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
- 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
- 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
- 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан
- 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд
- 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
  - 3.5.1 Төсвийн төлөвлөлт
  - 3.5.2 Төсвийн гүйцэтгэл
  - 3.5.3 Нэмэлт төсөв

### **4. АУДИТЫН ТАЙЛАН**

- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
  - 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
  - 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
  - 4.5.1 Завсрын аудитын талаар
  - 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

### **6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

#### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

2026.02.25 № УВА-2026/198/НӨ -СТА-ТЦС  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Увс аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Увс аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Увс аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн даргын 2025 оны Б/06, Б/12 дугаар тушаалуудаар нярвын орон тоог бий болгон 5,749.7 мянган төгрөгийн цалин хөлс, 776.2 мянган төгрөгийн ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, нийт 6,525.9 мянга, Стандарт, хэмжил зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид 2024 оны 3, 4 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулалт цалинг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/394 дүгээр тушаалаар 1,933.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Б/98 дугаар захирамжаар 1,539.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон, тайлант онд байгууллагын тодотгосон төсвийг 51,461.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн өр төлбөр үүсгэн санхүүгийн тайланд тусгасан, 1,595.0 мянган төгрөгийн 580 литр шатах тослох материалыг хүчин төгөлдөр бус баримтаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 дах заалтад "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.3 дах заалтад "Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16.5.9 дэх заалтад "Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох", Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.2 дахь заалтад "Албаны эрх мэдлээ хэтрүүлэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1

8525050634

дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.2 дах заалтад “Чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх”, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2-д “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй нь нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

#### **Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

#### **Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>30,550,127.59</b>	<b>109,086,349.45</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	5,961,159.84	86,246,365.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	961,159.84	00.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	81,246,365.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	5,000,000.00	5,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	5,000,000.00	5,000,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	24,588,967.75	22,839,984.45
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	24,588,967.75	22,839,984.45
35410	Бичиг хэргийн материал	452,900.00	345,900.00
35420	Аж ахуйн материал	22,068,087.75	19,842,194.45
35430	Сэлбэг хэрэгсэл	500,000.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	1,567,980.00	2,651,890.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>893,130,598.74</b>	<b>929,021,500.43</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	893,130,598.74	929,021,500.43
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	839,565,598.74	875,520,667.13
39201	Барилга, байгууламж, орон сууц	756,238,560.00	756,238,560.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-123,895,951.38	-140,654,098.62
39203	Авто-тээврийн хэрэгсэл	53,475,000.00	53,475,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-14,854,166.60	-23,766,666.56
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	268,278,214.34	367,967,564.34
39206	Хуримтлагдсан элэгдэл	-115,976,209.78	-158,197,666.11
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,990,896.70	48,385,796.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,690,744.54	-27,927,822.62
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	53,565,000.00	53,500,833.30
39301	Программ хангамж	385,000.00	385,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-64,166.70
39303	Бусад биет бус хөрөнгө	53,180,000.00	53,180,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>923,680,726.33</b>	<b>1,038,107,849.88</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>1,196,380.00</b>	<b>51,461,562.05</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	1,196,380.00	51,461,562.05
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	1,196,380.00	51,461,562.05
41361	Байгууллагад төлөх өглөг	1,196,380.00	43,029,562.05
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	8,432,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>922,484,346.33</b>	<b>986,646,287.83</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	922,484,346.33	986,646,287.83
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	109,019,739.50	109,019,739.50
51101	Өмч: - төрийн	109,019,739.50	109,019,739.50
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	804,599,119.88	868,761,061.38
51210	Өмнөх үеийн үр дүн	804,599,119.88	804,599,119.88
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	64,161,941.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,865,486.95	8,865,486.95
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>923,680,726.33</b>	<b>1,038,107,849.88</b>

## 2.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>989,863,631.40</b>	<b>1,056,093,901.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>309,106,496.40</b>	<b>285,099,215.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	309,106,496.40	285,099,215.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	226,808,239.40	201,246,365.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	226,808,239.40	201,246,365.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>680,757,135.00</b>	<b>770,994,686.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	680,757,135.00	720,382,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	666,501,235.00	695,396,400.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	14,255,900.00	24,986,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	50,612,286.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	50,612,286.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>953,051,483.89</b>	<b>991,931,959.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>953,051,483.89</b>	<b>991,931,959.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	770,266,670.89	918,538,308.65
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	486,000,832.40	539,267,340.09
210101	Үндсэн цалин	281,694,502.11	309,332,014.79
210102	Нэмэгдэл	138,140,072.80	138,972,526.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	37,943,684.00	43,456,060.27
210104	Урамшуулал	28,222,573.49	40,906,738.74
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	6,600,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	61,761,217.91	70,505,286.93
210201	Тэтгэврийн даатгал	41,359,598.53	48,099,182.46
210202	Тэтгэмжийн даатгал	4,865,574.43	6,423,578.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,432,786.73	5,022,774.65
210204	Ажилгүйдлийн даатгал	2,432,786.73	2,224,923.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,670,471.49	8,734,828.54
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	68,350,942.38	117,342,236.86
210301	Гэрэл, цахилгаан	828,000.00	5,250,839.86
210302	Түлш, халаалт	65,563,343.88	107,775,361.00
210303	Цэвэр, бохир ус	1,959,598.50	4,316,036.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	29,273,510.00	29,339,655.30
210401	Бичиг хэрэг	5,323,500.00	1,480,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,418,600.00	10,425,910.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,369,550.00	2,096,420.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,161,860.00	10,961,040.30
210408	Бараа материал акталсны зардал	00.00	4,276,285.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	14,742,110.00	10,399,410.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,262,110.00	8,110,390.00

210502	Хоол, хүнс	3,480,000.00	2,289,020.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,429,400.00</b>	<b>22,040,500.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,620,000.00	00.00
210604	Урсгал засвар	9,809,400.00	22,040,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>18,238,000.00</b>	<b>23,759,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	18,238,000.00	23,759,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>16,693,540.00</b>	<b>32,456,311.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,810,000.00	28,081,885.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	523,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	87,500.00	99,736.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	14,900.00	32,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	143,500.00	1,320,000.00
210807	Газрын төлбөр	1,057,000.00	531,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,733,640.00	1,957,990.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>63,777,118.20</b>	<b>73,193,348.31</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	926,500.00	682,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	317,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,850,618.20	72,193,348.31
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>182,784,813.00</b>	<b>73,628,871.01</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>3,943,712.00</b>	<b>00.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	3,943,712.00	00.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>161,054,233.94</b>	<b>12,931,198.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,074,733.94	12,931,198.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,489,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	80,490,300.00	00.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>60,697,673.01</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	60,697,673.01
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>17,786,867.06</b>	<b>00.00</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,786,867.06	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>36,812,147.51</b>	<b>64,161,941.50</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>36,812,147.51</b>	<b>64,161,941.50</b>

2.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>907,565,374.40</b>	<b>972,241,051.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>226,808,239.40</b>	<b>201,246,365.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	226,808,239.40	201,246,365.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	226,808,239.40	201,246,365.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	226,808,239.40	201,246,365.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>680,757,135.00</b>	<b>770,994,686.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	680,757,135.00	720,382,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	666,501,235.00	695,396,400.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	14,255,900.00	24,986,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	50,612,286.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	50,612,286.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>900,365,374.40</b>	<b>962,241,051.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>900,365,374.40</b>	<b>962,241,051.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>717,580,561.40</b>	<b>807,365,814.99</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	486,562,305.63	534,658,984.62
210101	Үндсэн цалин	281,639,742.11	307,258,053.82
210102	Нэмэгдэл	138,756,306.03	138,972,526.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	37,943,684.00	43,456,060.27
210104	Урамшуулал	28,222,573.49	38,372,344.24
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	6,600,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	60,821,994.37	68,070,092.51
210201	Тэтгэврийн даатгал	41,359,598.53	45,663,987.56
210202	Тэтгэмжийн даатгал	4,865,574.13	6,423,578.28
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,432,786.73	5,022,774.65
210204	Ажилгүйдлийн даатгал	2,432,786.71	2,224,923.48
210205	Эрүүл мэндийн даатгал	9,731,248.27	8,734,828.54
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	83,040,631.40	117,303,736.86
210301	Гэрэл, цахилгаан	828,000.00	5,250,839.86
210302	Түлш, халаалт	80,253,032.90	107,775,361.00
210303	Цэвэр, бохир ус	1,959,598.50	4,277,536.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,645,630.00	10,921,880.00
210401	Бичиг хэрэг	4,045,200.00	857,300.00
210402	Тээвэр, шатахуун	3,520,600.00	5,457,260.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,369,550.00	2,134,920.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	100,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,710,280.00	2,372,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	20,395,500.00	9,960,500.00

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,930,500.00	6,896,800.00
210502	Хоол, хүнс	3,465,000.00	3,063,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,441,500.00</b>	<b>19,510,700.00</b>
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,980,000.00	00.00
210604	Урсгал засвар	9,461,500.00	19,510,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>22,136,000.00</b>	<b>15,327,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	22,136,000.00	15,327,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>15,056,000.00</b>	<b>30,612,921.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,210,000.00	28,081,885.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	523,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	87,500.00	99,736.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	14,900.00	32,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	483,400.00	1,320,000.00
210807	Газрын төлбөр	1,057,000.00	531,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	356,200.00	114,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>3,481,000.00</b>	<b>1,000,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00	666,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	981,000.00	333,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>182,784,813.00</b>	<b>154,875,236.01</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>3,943,712.00</b>	<b>00.00</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	3,943,712.00	00.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>161,054,233.94</b>	<b>12,931,198.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,074,733.94	12,931,198.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,489,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	80,490,300.00	00.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>17,786,867.06</b>	<b>141,944,038.01</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,786,867.06	141,944,038.01
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>7,200,000.00</b>	<b>10,000,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>7,200,000.00</b>	<b>10,000,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>7,200,000.00</b>	<b>10,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>7,200,000.00</b>	<b>10,000,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,200,000.00	10,000,000.00

2.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	109,019,739.50	324,828.62	-70,693,390.24	00.00	38,651,177.88
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>109,019,739.50</b>	<b>324,828.62</b>	<b>-70,693,390.24</b>	<b>00.00</b>	<b>38,651,177.88</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	29,324,313.21	00.00	29,324,313.21
C08	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>109,019,739.50</b>	<b>8,865,486.95</b>	<b>804,599,119.88</b>	<b>00.00</b>	<b>922,484,346.33</b>
D01	<b>2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>109,019,739.50</b>	<b>8,865,486.95</b>	<b>804,599,119.88</b>	<b>00.00</b>	<b>922,484,346.33</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>109,019,739.50</b>	<b>8,865,486.95</b>	<b>804,599,119.88</b>	<b>00.00</b>	<b>922,484,346.33</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	64,161,941.50	00.00	64,161,941.50
D09	<b>2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>109,019,739.50</b>	<b>8,865,486.95</b>	<b>868,761,061.38</b>	<b>00.00</b>	<b>986,646,287.83</b>

2.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

ЭЗА	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	823,638,700.00	767,034,219.17	56,604,480.83	93.1%
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	823,638,700.00	767,034,219.17	56,604,480.83	93.1%
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	810,707,500.00	754,103,021.17	56,604,478.83	93.0%
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	550,724,800.00	518,883,763.69	31,841,036.31	94.2%
210101	Үндсэн цалин	315,545,400.00	307,258,053.82	8,287,346.18	97.4%
210102	Нэмэгдэл	136,409,100.00	129,797,305.36	6,611,794.64	95.2%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,403,400.00	43,456,060.27	8,947,339.73	82.9%
210104	Урамшуулал	46,366,900.00	38,372,344.24	7,994,555.76	82.8%
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	66,715,500.00	66,712,940.62	2,559.38	100.0%
210201	Тэтгэврийн даатгал	43,446,600.00	44,791,794.11	-1,345,194.11	103.1%
210202	Тэтгэмжийн даатгал	5,817,200.00	6,301,780.66	-484,580.66	108.3%
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,908,600.00	4,957,318.51	-2,048,718.51	170.4%
210204	Ажилгүйдлийн даатгал	2,908,600.00	2,165,263.61	743,336.39	74.4%
210205	Эрүүл мэндийн даатгал	11,634,500.00	8,496,783.73	3,137,716.27	73.0%
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	91,193,500.00	86,088,615.86	5,104,884.14	94.4%
210301	Гэрэл, цахилгаан	3,452,200.00	2,750,839.86	701,360.14	79.7%
210302	Түлш, халаалт	82,989,900.00	79,060,240.00	3,929,660.00	95.3%
210303	Цэвэр, бохир ус	4,751,400.00	4,277,536.00	473,864.00	90.0%
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,261,900.00	6,006,580.00	2,255,320.00	72.7%
210401	Бичиг хэрэг	1,494,600.00	362,600.00	1,132,000.00	24.3%
210402	Тээвэр, шатахуун	3,117,800.00	2,290,060.00	827,740.00	73.5%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,446,700.00	2,134,920.00	311,780.00	87.3%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	222,000.00	100,000.00	122,000.00	45.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	980,800.00	1,119,000.00	-138,200.00	114.1%
2105	<b>Нормативт зардал</b>	14,430,000.00	9,960,500.00	4,469,500.00	69.0%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,977,100.00	6,896,800.00	3,080,300.00	69.1%
210502	Хоол, хүнс	3,457,100.00	3,063,700.00	393,400.00	88.6%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	995,800.00	00.00	995,800.00	0.0%
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	19,510,700.00	19,510,700.00	00.00	100.0%
210604	Урсгал засвар	19,510,700.00	19,510,700.00	00.00	100.0%
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	15,976,000.00	15,327,000.00	649,000.00	95.9%
210702	Дотоод албан томилолт	15,976,000.00	15,327,000.00	649,000.00	95.9%
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	42,895,100.00	30,612,921.00	12,282,179.00	71.4%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	39,494,400.00	28,081,885.00	11,412,515.00	71.1%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00	00.00	100.0%
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	00.00	200,000.00	0.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	106,500.00	99,736.00	6,764.00	93.6%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	32,900.00	32,900.00	00.00	100.0%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,507,800.00	1,320,000.00	187,800.00	87.5%
210807	Газрын төлбөр	531,800.00	531,800.00	00.00	100.0%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	589,700.00	114,600.00	475,100.00	19.4%

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1000000.00	1000000.00	00.00	100.0%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	666,800.00	666,800.00	00.00	100.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	333,200.00	333,200.00	00.00	100.0%
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	12931200.00	12931198.00	02.00	100.0%
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	12,931,200.00	12,931,198.00	02.00	100.0%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,931,200.00	12,931,198.00	02.00	100.0%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	823,638,700.00	767,034,219.17	56,604,480.83	93.1%
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	703,638,700.00	565,787,854.17	137,850,845.83	80.4%
131001	Улсын төсвөөс санхүүжих	703,638,700.00	565,787,854.17	137,850,845.83	80.4%
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	120,000,000.00	201,246,365.00	-81,246,365.00	167.7%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,000,000.00	201,246,365.00	-81,246,365.00	167.7%
62	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	13	13	00.00	100.0%
620001	Удирдах ажилтан	01	01	00.00	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	07	07	00.00	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	05	05	00.00	100.0%
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	12	12	00.00	100.0%
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	07	07	00.00	100.0%
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	05	05	00.00	100.0%

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>63,262,793.82</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>63,262,793.82</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>63,262,793.82</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>15,775,220.93</b>
210102	Нэмэгдэл		9,175,220.93
210105	Гэрээт ажлын хөлс		6,600,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>1,357,151.89</b>
210201	Тэтгэврийн даатгал		872,193.45
210202	Тэтгэмжийн даатгал		121,797.62
210203	ҮОМШӨ-ний даатгал		65,456.14
210204	Ажилгүйдлийн даатгал		59,659.87
210205	Эрүүл мэндийн даатгал		238,044.81
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		<b>31,215,121.00</b>
210301	Гэрэл, цахилгаан		2,500,000.00
210302	Түлш, халаалт		28,715,121.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>4,915,300.00</b>
210401	Бичиг хэрэг		494,700.00
210402	Тээвэр, шатахуун		3,167,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,253,400.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>10,000,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл		10,000,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>63,262,793.82</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>63,262,793.82</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		24,986,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		38,276,793.82
IV	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс нь орон нутагтаа худалдаа үйлчилгээний тооцоо, хүн мал эмнэлгийн шинжилгээ, эмчилгээ, оношилгоо, байгаль орчны хамгаалал, улсыг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн бүхий л үйл ажиллагаанд ашиглаж байгаа хэмжүүр, хэмжих хэрэгслийг итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтын дагуу баталгаажуулалтад бүрэн хамруулах, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, буруу хэмжлийн үр дагавраас эдийн засаг, нийгэм, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, материаллаг баялгийг бодит хэрэглээ, зарцуулалтыг үнэн зөв, нарийн тооцож, хэмжихэд хэмжилзүйн ажил, үйлчилгээ үзүүлдэг байгууллага юм.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.
- ✓ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон.
- ✓ Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд - 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр, 2024 оны 06 дугаар сарын 16-ны өдөр, 07 дугаар сарын 07-ны өдөр, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 328,940.1 мянган төгрөгөөр буюу 41.8 хувиар өссөн байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	5,961.2	86,246.4	80,285.2
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	24,589.0	22,840.0	-1,749.0
Үндсэн хөрөнгө	893,130.6	929,021.5	35,890.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>923,680.7</b>	<b>1,038,107.8</b>	<b>114,427.1</b>
Өр төлбөр	1,196.4	51,461.6	50,265.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	922,484.3	986,646.3	64,162.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>923,680.7</b>	<b>1,038,107.8</b>	<b>114,427.1</b>

Авлага дансны үлдэгдэл 86,246.4 мянган төгрөг болж 80,285.2 мянган төгрөгөөр өссөн нь Сангийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 240 тушаалаар үйл ажиллагааны давсан орлогыг авлагад тооцон бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 22,840.0 мянган төгрөг болж 1,749.0 мянган төгрөгөөр буурсан нь бичиг хэрэг, аж ахуйн материал, сэлбэг хэрэгслийн материалын үлдэгдэл буурсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 929,021.5 мянган төгрөг болж 35,890.9 мянган төгрөгөөр өссөн нь бусад эх үүсвэрээс 80,881.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 18,807.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 8,394.9 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл тус тус нэмэгдсэн, тайлант оны 72,193.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсонтой холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 51,461.6 мянган төгрөг болж 50,265.2 мянган төгрөгөөр өссөн нь ажилчидтай холбоотой 7,278.8 мянга, дотоод албан томилолтын 8,432.0 мянга, байгууллагад төлөх 35,750.8 мянган төгрөгийн өр төлбөр байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 986,646.3 мянган төгрөг болж 64,162.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Увс аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 950,456.0 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 120,000.0 мянга, нийт 1,070,456.0 мянган төгрөгөөр, урсгал зардлыг 1,070,456.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг улсын төсвөөс 211,556.0 мянган төгрөгөөр бууруулан 858,900.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 35,261.3 мянган төгрөгөөр бууруулан тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 703,638.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, үндсэн үйл ажиллагааны орлогоос 120,000.0 мянган төгрөг тус тус бүрдүүлэхээр байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 767,034.2 мянган төгрөг буюу 93.1 хувьтай байгаа байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70407-Стандартчилал, хэмжил зүй, 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	651,213.1	606,021.1	45,192.0	94.1%
2	70407-Стандартчилал, хэмжил зүй, 80205-Мэдээлэл, сурталчилгааны зардал	0.0	0.0	0.0	
3	70407-Стандартчилал, хэмжил зүй, 80219-Харуул, хамгаалалтын зардал	39,494.4	28,081.9	11,412.5	72.9%
4	70407-Стандартчилал, хэмжил зүй, 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж,	12,931.2	12,931.2	0.0	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/			
№	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	385.0	Санхүүгийн программын тайлант оны зардал 1,320.0 мянган төгрөг
2	Унаа, хоолны зардал	43,456.1	2025 онд 43,456.1 мянган төгрөгийн хоолны зардал олгосон байна.
3	Сургалт, семинар	2,703.0	Удирдах ажилтны зөвлөгөөнд оролцсон томилолтын зардал
4	Гадаад томилолт, арга хэмжээ	0.0	Гадаад томилолт, арга хэмжээ зардал гараагүй байна.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	0.0	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.
6	Хэвлэл мэдээлэл	0.0	Хэвлэл мэдээллийн арга хэмжээнд зардал гараагүй байна.
7	Орон тоо	534,658.9	Тайлант онд 21 орон тоотой ажиллахаар батлагдсанаас 19 орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Увс аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн нэмэлт санхүүжилтийн дансанд ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 24,986.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 38,276.8 мянга, нийт 63,262.8 мянган төгрөгийн орлого хүлээн авч зарцуулалтын эрх нээлгэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Увс аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс нь тайлант онд 38,110.1 мянган төгрөгийн бараа материал, 27,202.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүхий худалдан авалт хийсэн байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Амармэнд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 13 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны төсвийн нийт зардлын 953,051.5 мянган төгрөгийн 1 хувиар буюу 9,530.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 991,932.0 мянган төгрөгийн 1 хувиар буюу 9,919.3 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 7,935.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Увс аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.2 дах заалтад “Чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох” гэж заасныг зөрчин Стандарт хэмжил зүйн хэлтсийн даргын 2025 оны Б/06, Б/12 дугаар тушаалуудаар нярвын орон тоог бий болгон 5,749.7 мянган төгрөгийн цалин хөлс, 776.2 мянган төгрөгийн ажил олгогчоос төлөх нийгэм даатгалын шимтгэл нийт 6,525.9 мянган төгрөгийг зарцуулсанд зөвлөмж өгөв.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 183 мэдээллээс хугацаандаа оруулсан 177, хугацаа хоцроон байршуулсан 4, мэдээлэх хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Увс аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Увс аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөвлөмж өгснийг 2025 оны 06



дугаар сарын 19-ний өдрийн 53 дугаар албан бичгээр биелэлтийг тайлагнан санхүүгийн аудитын fas.audit.mn цахим системд байршуулсан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Увс аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8 дах заалтад “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг зөрчин байгууллагын тодотгосон төсвийг 51,461.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн өр төлбөр үүсгэн санхүүгийн тайланд тусгасан байна.

Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дах хэсэгт “Төсвийн захирагч тухайн жилийн батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн нь албан тушаалаас чөлөөлөх үндэслэл болно” гэж заасан байна. Тухайн үед ажиллаж байсан дарга нь нас барсан, нягтлан бодогч нар чөлөөлөгдсөн учраас холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцуулах албан шаардлага өгөх боломжгүй байна. Иймд Төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяалах төсвийн шууд захирагч нарын батлагдсан төсөв, гүйцэтгэлд хяналтыг тухай бүр хэрэгжүүлэн зөвлөмж чиглэл хүргүүлэн ажиллах шаардлагатай байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 145,972.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 86,445.8 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 1,539.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 57,987.4 мянган төгрөгийн 2 зөрчилд 2 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа:

1. Тайланд оны үйл ажиллагааны давсан орлого 81,246.4 мянган төгрөгийг Сангийн сайдын 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 240 дүгээр тушаалыг үндэслэн авлагаар бүртгэснийг санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.
2. Албан хаагчдад олгосон 4 дүгээр улирлын үр дүнгийн урамшууллын нийгмийн даатгалын шитгэлийн 5,199.4 мянган төгрөгийг дутуу шилжүүлснийг өр төлбөрөөр бүртгээгүй байсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3 дахь заалтад “Бүх өр төлбөр”, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтад “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчсөн тул санхүүгийн тайланд өглөгөөр бүртгэж залруулга хийлгэлээ.

#### 5.1 Төлбөрийн акт

Увс аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид 2024 оны 3, 4 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулалт цалинг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/394 дүгээр тушаалаар 1,933.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Б/98 дугаар тушаалаар 1,539.0 мянган төгрөгийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.2 дахь заалтад “Албаны эрх мэдлээ хэтрүүлэх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.9-д “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх”, 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.3-д “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2-д “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Давхардуулан олгосон үр дүнгийн урамшуулал 1,539.0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

**5.2 Зөвлөмж-1 Илрүүлэлт: Орон тоотой холбоотой**

Увс аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дах заалтад “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.9 дэх заалтад “Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1 дэх хэсэгт “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 15.1.2 дах заалтад “Чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох” гэж заасныг зөрчин Стандарт хэмжил зүйн хэлтсийн даргын 2025 оны Б/06, Б/12 дугаар тушаалуудаар нярвын орон тоог бий болгон 5,749.7 мянган төгрөгийн цалин хөлс, 776.2 мянган төгрөгийн ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл нийт 6,525.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

**Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дах заалтад “Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.9 дэх заалтад “Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрснөөр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсвийн хүрээнд шинэчлэн тогтоох” гэснийг мөрдөж ажиллах.

**Зөвлөмж-2 Илрүүлэлт: Өр төлбөртэй холбоотой**

Увс аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8 дах заалтад “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг зөрчин байгууллагын тодотгосон төсвийг 51,461.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн өр төлбөр үүсгэн санхүүгийн тайланд тусгасан, 1,595.0 мянган төгрөгийн 580 литр шатах тослох материалыг гарын үсгийн бүрдэл дутуу баримтаар зарцуулсан байна.

**Өгсөн зөвлөмж:**

Хүчин төгөлдөр анхан шатны баримтаар ажил, гүйлгээг бүртгэж, батлагдсан төсвийн хүрээнд зарцуулалт хийх.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Увс аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтэс	2	86,445.8	2	86,445.8			2	86,445.8				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>86,445.8</b>										

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Үүнээс

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Стандарт, хэмжил зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчид 2024 оны 3, 4 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулалт цалинг Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/394 дүгээр тушаалаар 1 933 000 төгрөг, аймгийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Б/98 дугаар тушаалаар 1 539 000 төгрөгийг давхардуулан олгосон байна.	1	1,539.0	1	1,539.0								
Стандарт хэмжил зүйн хэлтсийн даргын 2025 оны Б/06, Б/12 дугаар тушаалуудаар нярвын орон тоог бий болгон 5,749.7 мянган төгрөгийн цалин хөлс, 776.2 мянган төгрөгийн ажил олгогчоос төлөх нийгэм даатгалын шимтгэл нийт 6,525.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	6,525.9					1	6,525.9				
Байгууллагын тодотгосон төсвийг 51,461.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн өр төлбөр үүсгэн санхүүгийн тайланд тусгасан, 1,595.0 мянган төгрөгийн 580 литр шатах	1	51,461.5					1	51,461.5				

тослох материалыг гарын үсгийн бүрдэл дутуу баримтаар зарцуулсан байна.													
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>59,526.4</b>	<b>1</b>	<b>1,539.0</b>			<b>2</b>	<b>57,987.4</b>					

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
<b>Нийт дүн</b>								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



2026 оны 02 сарын 24-ний өдөр